

„Бидний Дэлхий“ ойн төглийн төсөл

Заамарын байгаль орчныг сэргээх



Санаачлагч :

Дуламжавын Эрдэнэчулуун
Wriezener Karree
D - 10243 Berlin / Улаанбаатар
Мэйл : edulamjav@yahoo.de
Интернет : <http://enkhsaikhan.posterous.com>


Төслийн Зохицуулагч :

Диплом-Инф. Хэйнц Р. Эттэл
EN&P Environment & Protection
D - 86163 Augsburg-Hochzoll
Мэйл : office@enp-beratung.de
Интернет : www.enp-beratung.de

Мэргэжлийн зөвлөх :

Диплом-Инж. Хэрманн Баргэс
Цэцэрлэгийн Архитект / хувийн хэвшлийн
STADTplusLANDSCHAFT
D - 12049 Berlin
Мэйл : stadtpluslandschaft@arcor.de
Интернет : www.stadtpluslandschaft.de
www.oeko-design.net

Одоогийн төрх байдал



Туул гол Монголын умард нутгаас эх авч, нийслэл Улаанбаатарыг дамжин Байгаль нуурт цутгадаг, нийт 820 км урт. Туул гол Заамарыг тойрон урасдаг.

Заамар Улаанбаатараас 180 км зайтай ба Төв аймгийн нутагт оршино. Баруун талаараар нь туул гол урсах ба голын сав хүдэр, алтны их хэмжээний нөөцтэй. Засгийн газрын 1993 оны алт олборлох тухай хөтөлбөрийн хэмжээнд Заамарын нутаг дэвсгэрийн гуравны нэгд хайгуулалт, олборлолтын эрх олгосон байдаг. Энэ нь эндэхийн орон нутаг, орчны хот суурин болон тэдгээрийн харьцаанд экологийн том аюулыг авчирсан. Усны нөөцийг үрэлгэн ашиглаж, олборлолтын дараа нөхөн сэргээх арга хэмжээг орхигдуулснаар олон жижиг гол горхи - түүгээр ч үл барам бүхэл бүтэн нуур ширгэсэн.

Үүний зэрэгцээ голын сав, ус, орчин тойрон нь мөнгөн ус мэтийн хүнд төмөрлөгөөр бохирдсон. Голын эргийг дагуух овгор шороо, халцархай талбайнууд нь салхины нөлөөгөөр үүсэх хөрсний элэгдлийг түргэтгэж цөлжилт бий болгоход ихээр нөлөөлж байгаа.



Уул уурхайн олборлолтод хуучирсан арга, технологи ажигласнаар Туул, Орхон болон Сэлэнгэ голууд их бохирдсон. Эдгээр голууд нь Байгаль нууранд цутгадаг ба ингэснээр дэлхийн цэвэр усны хамгий төм нөөц болох энэ нуур бохирдож эхэлсэн. Байгаль орчныг нь нөхөн сэргээх нь зөвхөн Заамар сум, Монгол, Орос Улстай холбоотой бус бүр бүрэн хэмжээний шийдвэр даруй шаардаж байгаа олон улсы хэмжээний экологийн асуудал болоод байна.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр жижиг том нийлсэн нийтдээ 250 гаруй алтны уурхай ажиллаж байгаа. Албан ёсний мэдээллээр Заамар суманд 1993 оноос 2003 оны хооронд 35 орчим алтны уурхай бүртгэгдсэн байдаг ба үүнээс 29 нь нийт 2.215 гектар талбайд олборлолт явуулсан болов ч нөхөн сэргээлт хийх ямар ч оролдлого хийлгүйгээр туйлийн хэцүү байдалд орхисон.



Уурхайн байгаль орчныг нөхөн сэргээлт нь иж бүрэн үйл ажиллагаа байдаг ба их жэмжээний хөрөнгө цаг хугацаа шаарддаг. Эрдэмтдийн тооцоогоор бороо хур багатай газрын байгаль орчинг нөхөн сэргээхэд дор хаяж 10-аас 15 жилийн хугацаа шаардагддаг хүнд хөсөр ажил байдаг.



Уул уурхайн олборлолт явуулж байгаа газруудад санхүүгийн туслалцаа хэдийгээр үзүүлдэг болов ч, ихэнх нь нөхөн сэргээлтийн ажлыг нарийн концептгүйгээр гүйцэтгэдэг учир үр дүнгүй болдог. Түүнээс гадна, биологийн нөхөн сэргээлтийг, экологийн дэвшилттэй технологи, норм норматив болон шаардлагийн дагуу хийж гүйцэтгэхэд тохирсон удирдлагийн системийг бүрдүүлэх тодорхой алхмууд хийгдээгүй. Ингэснээр иргэд тухайн орон нутгаас нүүн шилжихээс гадна нөхөн сэргээлтийг орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч байсан явдлууд бий.



Тосон-Заамар хөдөлгөөний санаачилсан Ногоон-Нуур төслийн хүрээнд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, хариуцах Яамд болон албан газруудаас тусламж хүссэн боловч амлаад л өнгөрсөн.

Олон хүмүүсийн амьдрах орчинг сүйтгэж, хордуулж байгаа энэхүү газар нутгийн байгаль орчинг яаралтай сэргээх шаардлагатай байна.

Иймд бид үүгээр бүрэн хэмжээний, хөрөнгө бага шаардах, тэндэхийн хүмүүсийн амьдралд шинэ сайхан нөхцөл байдлыг бүрдүүлэх нөхөн сэргээлтийн товчхон санааг дэвшүүлэе!



Гол санаанууд

1. Нийгэм болон зохицуулалтийн талаар

- Засгийн газар болон бусад албан байгууллагатай хамтран ажиллах
- Иргэдийг нөхөн сэргээлтийн арга хэмжээний бүх үе шатанд хамруулах
- Боломжийн орон сууцаар хангах
- Иргэдийг ажлын байраар хангаж, цалин хөлснийх нь асуудлыг бүрэн шийдснээр хууль бусаар ухаж малтах явдлыг зогсоох
- Туул голын орчмыг нөхөн сэргээх ажлыг, билчээрийн талбай бий болгох арга хэмжээтэй уялдуулан гүйцэтгэх
- Төслийн ажлын бүх үе шат, түүний гүйцэтгэл, хэтийн төлвийг ил тод байлгах зорилгоор иргэдэд шаардагдах мэдээллүүдийг шуурхай олгож байх. Төслийн тэнцвэртэй хөгжил, Экологийн харилцан уялдааны талаар сургалт зохион байгуулах.
- Гадаадаас авч болох тусламж тусалцааны боломжийг эрж хайх
- Төсөлд үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах боломжийг хайх (жиш : Rotary Club Korea/Ulan-Bator)

Төсөлд хувь хүмүүс, үйлдвэр аж ахуйн газруудыг дэлхийн аль ч өнцгөөс оролцох боломжийг нээж өгөх („[Бидний Дэлхий](#)“ ойн төглийн төсөл“)

2. Гүйцэтгэх ажлууд

Бага хүрээний нэгэн төв цэгээс эхлэн өргөтгөх шугмаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ :

- Хөрсний нөхөн сэргээлт хийх
- Голын голдрилыг сэргээх
- Овоолсон шороо, хонхор газруудыг тэгшлэх
- Нүх, уурхайн дотоод замуудыг битүүлэх
- Хөрсөнд тэгшлэлт, нөхөн сэргээлт хийх явцад бордоог зэрэг ашиглана
- Хүн, малыг ундны цэвэр усаар хангах
- Усыг конденсацын аргаар мөнгөн ус, хүнцэл, хагас болон хүнд төмөрлөгөөс цэвэршүүлэх
- Хөрсний усыг цэвэршүүлэх үед усны байглийн эргэлтийн нөөцийн хэмжээг алдагдуулахгүй байх
- Бордоо ажигласан хашлага бүхий билчээрийн талбай бий болгох
- Дахин ашиглагдах материалаар хийсэн, модулиар угсарах аргаар барих, түлш болон цахилгааны өндөр хэмнэлттэй жижиг орон сууцаар хангах
- Тулшний модны оронд ургамлын тосыг ажиглах боломжийг бүрдүүлж ой модыг хамгаалах
- Голын эрэг дагуу болон орчны хөрсний элэгдэлтэй талбайд тохирох ургамлыг сонгон ургуулах. Шинээр тарьсан мод, бут сөөг, зүлэг ногоог эхний үед торлож хамгаалах

- Нөхөн сэргээх ажиллагааг төслийн бүх үе шатанд, төлөвлөлтийн дагуу цаг тутамд нь өргөжүүлэн төсөлд тусгасан бүх талбайд хэрэгжүүлнэ
- Орон нутаг, төслийн талаар үндэсний болон олон улсын хэмжээнд сурталчилгаа явуулах, хөдөө аж ахуй, аялал жуулчлал хөгжүүлэхэд ашиглах
- Орон нутгийн болон удирдах дээд байгууллагууд, засаг дарга нартай хамтран иргэдийг өргөнөөр оролцуулсан аялал жуулчлалын өвөрмөгц арга хэмжээнүүдийг төлөвлөх
- Лиценз олгох
- Аялал жуулчлалын бааз байгуулах

3. Мэргэжлийн арга хэмжээнүүд

Нийт асуудалд, цаашид хэтдээ бие даасан, хүн байгальтайгаа зохицон амьдрах боломж бүрдүүлэх арга замаар хандах болно.

Үүнд :

- Тухайн орчинд тохирсон, орон нутгын эдийн засагт ашиглаж болох бүхий ургамал (жимсний, навчит болон шилмүүст мод), гүн үндэстэй хуурай орчинд ургах чадвартай бут сөөгийг сонгох
- Ургамлын үндсийг чийгээр тогтвортой хангаж, нэмэлт усалгааг бараг эсвэл бүр мөсөн шаардлагагүй болгох хөрсний бордоо, сайжруулагчийг ашиглах



- Ургамлын үндсийг шим тэжээлээр удаан хугацаагаар хангах хөрсний бордоо, сайжруулагчийг ашиглах



- Ургамлын үндэсний өсөлтийг сайжруулж, салхиар өдөөгдөх хөрсний элэгдлийг бууруулахад чиглэгдсэн үндэстэй хослон нэгдэх бодисыг ашиглах



- Голын, болон хөрсний гүний усны боловсруулалтад Германы конденсацын шүүлтүүргүй аргийг хэргэлнэ. Энэ техник дулааны эх үүсвэртэй байх тохиолдолд хямд төсөр байдаг. Модулиар угсаран, контейнерт суурилуулсан энэ техникт дулааны насос, солармодуль, дизель/хийн түрбин болон модуль бүтэцтэй дулааны станцыг ашиглаж болно.

- Хүн малын ундааны усыг конденсацын аргаар тусад нь бэлтгэх. Төхөөрөмжийг дураараа өөрчлөх боломжтой ба агаарын чийгнээс ус боловсруулна (Humidity)
- Экологи эрчим хүчний хамгамжийн бүтэц (биохимийн, нарны энергийн, бага оврын салхин тээрмийн)



- Биологийн хаягдлаас эрчим хүч : Дэрс, Зүлэг ногоо, Навч, Ялзмаг, Амьтны баас (Гахай, Үхэр, Шувуу), Малын ялгадас, Бохир усны дамжуулах тохооромжийн лаг, Жимс ногооны үлдэгдэл, хоол ундны үлдэгдэл г.м.

- **Экологийн компонентуудыг бий болгох техникийн шийдлүүд нь эргэлтийн иж бүрэн системийг бүрдүүлнэ. Зөвхөн „Green / Clean Technology“ ашиглана**

